



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/428

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 13.4, 14.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2226 жил, Их монгол улсын 811 жил, Ардын хувьсгалын 96 жилийн ой, аймгийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан “Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн холбоо”-нд 1300000 төгрөгийн, МАНЗ-ын илгээлтийн эздийн анхдагч барилгачдын эрх ашгийг хамгаалах “Баатар холбоо”-нд 800000 төгрөгийн, “Эрдэнэтийн анхдагч барилгачин дайчдын холбоо”-нд 500000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 2600000 /Хоёр сая зургаан зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын “Ахмад настны сар шинийн хүндэтгэл, нийгмийн халамжийн зөвлөлийн арга хэмжээний зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д. БАТЛУТ